



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 42

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Цэцэрлэгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. 2017 оны 6.7-р сард нүүдлийн бүлэгт ажилласан ажиллагсдадын цалингаас ХХОАТ-ыг 165.0 мянган төгрөгөөр дутуу тооцож суутгасан.
2. Эрхлэгчийн 2017.12.20-57 тоот тушаалаар сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 600.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 24.1-д "энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн татварт 84.0 мянган төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ", Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**





D:\2018 on akt\Galuut sumiin tsetserleg_akt - Copy.docx

2517113

1. Дутуу суутгасан татвар болон зориулалт бусаар олгосон 705000 / Долоон зуун таван мянган/ төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Галуут сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Сайнзаяа, нягтлан бодогч С.Ариунжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН 1:	ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ	ГАЛУУТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
 6417 43544 БЧОАГТ 9007423	ЭРХЛЭГЧ  Б.САЙНЗАЯА
	НЯГТЛАН БОДОГЧ  С.АРИУНЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 42

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Цэцэрлэгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад багш Б.Энхмаа тахир дутуугийн группт байдгаас цалингаас нийт шимтгэлийг 16.6 хувиар тооцож НДХ-т хөнгөлөлттэй мэдээлсэн атлаа нягтлан бодогч 2014-2017 онуудад цалингийн сангаас 21%-иар тооцож санхүүгийн тайланд шимтгэлийн өглөг үүсгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 727,9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журмын 16.1-т “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “Нягтлан бодох бүртгэлд ... авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад

D:\2018 on akt\Galuu sumiin tsetserleg_akt.docx



2517115

нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалингаас илүү суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн 357.294 төгрөгийг Б.Энхмаад олгож, байгууллагаас төлөх шимтгэлийн зардлын авлага 370.6 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Галуут сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Сайнзаяа, нягтлан бодогч С.Ариунжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН 1:	ЗӨВШӨӨРСӨН:
 АХЛАХ АУДИТОР А.ЦЭЭНЯМ	 ГАЛУУТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.САЙНЗАЯА НЯГТЛАН БОДОГЧ С.АРИУНЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 68

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. Аймгийн Засаг даргын шийдвэргүйгээр сургуулийн захирал С.Оюунд 300.0 мянган төгрөгийг урамшуулал олгосон.
2. 2016 онд олгосон ажиллагсдад олгосон урьдчилгаа цалингийн авлагын 680,0 мянган, цалингаас суутгасан ҮЭ-ийн татварын илүү төлөлт 372693 төгрөгийн авлагыг тус тус цалин, холбогдох тооцооноос суутган тооцож барагдуулаагүй.
3. Давхарын нуруу хоршоонд малын тарилга туулганы хөлсөнд 2017.06.20-нд 73.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэл, Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

D:\2018 on akt\Jargalant surguuli_akt .docx

2518017

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвөөс төлсөн малын тарилгын хөлс 73,0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, зориулалт бусаар олгосон 270,0 мянган төгрөгийг С.Оюунаар, урьдчилгаа цалингийн 250,0 мянган төгрөгийг А.Ариунаагаар, 280,0 мянган төгрөгийг Д.Амардэлгэрээр, 150,0 мянган төгрөгийг Б.Жанчиваар, 372693 төгрөгийг ҮЭ-ийн татвараас суутган тооцож, нийт 1395693 / Нэг сая гурван зуун ерэн таван мянга зургаан зуун ерэн гурван/ төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Оюун, нягтлан бодогч Б.Өлзийбуян нарт хариуцуулав.

АКТЫГ

<p>ТОГТООСОН¹:</p> <p>АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ</p>  <p>6417143544 Б-ДААН 67 9007423</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>ЖАРГАЛАНТ СУМЫН ЕБС-ИЙН ЗАХИРАЛ  С.ОЮУН НЯГТЛАН БОДОГЧ  Б.ӨЛЗИЙБУЯН</p>  <p>10001</p>
---	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.